



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/139/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn “Баянташаагийн эх аудит” ХХК-ний аудитор: Ч.Чимгээ Утас: 89915909 Цахим хаяг: bte.audit@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3.Аудитын тайлан	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт	13
Залруулсан алдаа	14
Аудитын зөвлөмж	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Менежментийн захидал.....	14
5. Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Б А Я Н Х О Н Г О Р А Й М Г И Й Н ХҮРЭЭМАРАЛ
С У М Ы Н ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ Г.БАЙГАЛМАА ТАНАА

2021.02.25 № 2/69

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Аймгийн Эрүүл мэндийн газрын газрын дарга баталж, гүйцэтгэлийн тайланг Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч тайлагнасан байна.

Тус эрүүл мэндийн төвийн орчин үеийн технологийг эмчилгээнд нэвтрүүлэн, нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг

2021 А4 ТООТ

• 005021038

тасралтгүй зарчмаар стандартын дагуу чанартай тэгш, хүртээмжтэй үзүүлэх ажлын гүйцэтгэл, үйлчилгээний чанарын асуудлыг байгууллагын удирдлага хэрэгжүүлдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТӨРГҮҮДЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,592,945.40	63,935,991.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,296,945.40	63,935,991.00
351	Түүхий эд материал	8,430,935.00	26,587,751.00
35110	Тусгай зориулалттай материал	8,430,935.00	26,587,751.00
354	Хангамжийн материал	32,866,010.40	37,348,240.00
35410	Бичиг хэргийн материал	676,480.00	877,550.00
35420	Аж ахуйн материал	29,790,740.00	35,141,540.00
35440	Тулш, шатах тослох материал	00.00	800,000.00
35460	Хүнсний материал	2,398,790.40	529,150.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	150,728,714.91	140,924,238.85
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	150,728,714.91	140,924,238.85
392	Биет хөрөнгө	139,114,714.91	129,310,238.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	89,032,377.00	89,032,377.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-15,488,521.68	-30,977,043.36
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34,640,000.00	66,140,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,547,777.77	-24,936,944.41
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	127,308,379.27	127,308,379.27
39206	Хуримтлагдсан элэгдэл	-88,913,073.55	-103,682,232.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,974,086.50	17,974,086.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,114,754.86	-11,772,383.57
39217	Ном	224,000.00	224,000.00
393	Биет бус хөрөнгө	11,614,000.00	11,614,000.00
39301	Програм хангамж	650,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-650,000.00	-450,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	11,614,000.00	11,614,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	192,321,660.31	204,860,229.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	176,610.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	176,610.00
413	Өглөг	00.00	176,610.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	176,610.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	192,321,660.31	204,683,619.85
51	Засгийн газрын хувь оролцоо	192,321,660.31	204,683,619.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	175,490,678.27	175,490,678.27
51101	Өмч: - төрийн	175,490,678.27	175,490,678.27
512	Хуримтлагдсан үр дүн	-110,939,593.85	-98,577,634.31
51210	Өмнөх үеийн үр дүн	-110,939,593.85	-110,939,593.85
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	12,361,959.54
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	127,770,575.89	127,770,575.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	192,321,660.31	204,860,229.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	395,510,742.00	453,605,076.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,443,900.00	48,578,602.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,443,900.00	48,578,602.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,443,900.00	48,578,602.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,443,900.00	48,578,602.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375,066,842.00	405,026,474.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	332,647,100.00	345,117,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,647,100.00	345,117,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,400.00	21,224,734.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	117,400.00	21,060,334.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд оги болсон нэмэлт орлого	00.00	164,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,501,700.00	20,939,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,501,700.00	20,939,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,800,642.00	17,744,940.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,098,882.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,701,760.00	17,744,940.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	406,613,477.44	441,243,116.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406,613,477.44	441,243,116.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,080,814.44	429,177,527.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,264,722.00	274,256,065.00
210101	Үндсэн цалин	232,264,722.00	192,229,358.00
210102	Нэмэгдэл	00.00	58,083,633.00
210104	Урамшуулал	00.00	23,943,074.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,735,051.00	35,320,261.00
210201	Тэтгэврийн даатгал	21,800,850.00	24,427,849.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,589,690.00	2,914,765.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,012,872.00	2,241,092.00
210204	Ажилгүйдлийн даатгал	484,693.00	519,271.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,846,946.00	5,217,284.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,127,668.00	17,328,729.00
210301	Гэрэл, цахилгаан	1,842,908.00	2,627,229.00
210302	Түлш, халаалт	17,284,760.00	14,701,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,776,525.00	20,487,793.00
210401	Бичиг хэрэг	2,339,720.00	2,349,980.00
210402	Тээвэр, шатахуун	15,627,590.00	14,499,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,390,365.00	1,472,913.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,355,750.00	1,699,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,100.00	465,700.00
2105	Нормативт зардал	33,737,902.00	25,051,773.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,952,012.00	16,654,133.00
210502	Хоол, хүнс	7,290,890.00	7,404,640.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,495,000.00	993,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,405,535.20	4,877,937.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	194,000.00	103,087.00
210604	Урсгал засвар	9,211,535.20	4,774,850.00
2107	Томилолт, зочны зардал	1,250,000.00	2,424,000.00
210702	Дотоод албан томилолт	1,250,000.00	2,424,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,586,662.00	1,787,465.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,586,662.00	937,465.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	850,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,196,749.24	47,643,504.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,092,603.80	6,339,028.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,104,145.44	41,304,476.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,532,663.00	12,065,589.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,098,882.00	12,035,334.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,098,882.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан алаан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,035,334.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	433,781.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	433,781.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	16,171.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	16,171.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	14,084.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	14,084.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-11,102,735.44	12,361,959.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-11,102,735.44	12,361,959.54

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	375,066,842.00	405,026,474.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375,066,842.00	405,026,474.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	332,647,100.00	345,117,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,400.00	21,224,734.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	117,400.00	21,060,334.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	164,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,501,700.00	20,939,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,501,700.00	20,939,400.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,800,642.00	17,744,940.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,098,882.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,701,760.00	17,744,940.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	375,066,842.00	405,026,474.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	375,066,842.00	405,026,474.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	371,534,179.00	392,960,885.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	237,244,735.00	269,438,299.00
210101	Үндсэн цалин	174,855,700.00	182,517,099.54
210102	Нэмэгдэл	49,412,135.00	68,642,487.46
210104	Урамшуулал	12,976,900.00	18,278,712.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,657,100.00	33,679,900.00
210201	Тэтгэврийн даатгал	20,166,800.00	22,902,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,372,600.00	2,694,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,898,100.00	2,155,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	474,500.00	538,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,745,100.00	5,388,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,944,568.00	17,328,729.00
210301	Гэрэл, цахилгаан	1,842,908.00	2,627,229.00
210302	Түлш, халаалт	12,101,660.00	14,701,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,780,774.00	20,663,100.00
210401	Бичиг хэрэг	1,496,200.00	1,197,500.00
210402	Тээвэр, шатахуун	14,427,309.00	14,499,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,390,365.00	2,016,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,466,900.00	2,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	950,000.00
2105	Нормативт зардал	32,903,662.00	22,678,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	22,374,712.00	14,478,100.00
210502	Хоол, хунс	7,239,950.00	5,750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,289,000.00	2,450,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,625,000.00	4,844,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,725,000.00	1,250,000.00
210602	Тавилга	1,400,000.00	00.00
210604	Урсгал засвар	7,500,000.00	3,594,500.00
2107	Томиллолт, зочны зардал	1,620,000.00	1,474,000.00
210702	Дотоод албан томиллолт	1,620,000.00	1,474,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,084,600.00	11,532,465.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,684,600.00	10,682,465.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	850,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,673,740.00	11,321,792.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,673,740.00	11,321,792.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,532,663.00	12,065,589.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,098,882.00	12,035,334.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,098,882.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,035,334.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	433,781.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	433,781.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	16,171.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	16,171.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	14,084.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	14,084.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,490,678.27	127,770,575.89	-100,106,858.41	00.00	203,154,395.75
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175,490,678.27	127,770,575.89	-100,106,858.41	00.00	203,154,395.75
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-11,102,735.44	00.00	-11,102,735.44
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,490,678.27	127,770,575.89	-110,939,593.85	00.00	192,321,660.31
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	175,490,678.27	127,770,575.89	-110,939,593.85	00.00	192,321,660.31
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	175,490,678.27	127,770,575.89	-110,939,593.85	00.00	192,321,660.31
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	12,361,959.54	00.00	12,361,959.54
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	175,490,678.27	127,770,575.89	-98,577,634.31	00.00	204,683,619.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	383,813,000.00	383,771,485.00	-41,515.00	99.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	383,813,000.00	383,771,485.00	-41,515.00	99.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	383,813,000.00	383,771,485.00	-41,515.00	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,438,600.00	269,438,299.00	-301.00	100.00
210101	Үндсэн цалин	182,517,100.00	182,517,099.54	-0.46	100.00
210102	Нэмэгдэл	68,669,800.00	68,642,487.46	-27,312.54	99.96
210104	Урамшуулал	18,251,700.00	18,278,712.00	27,012.00	100.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,679,900.00	33,679,900.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	22,902,300.00	22,902,300.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,694,400.00	2,694,400.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,155,500.00	2,155,500.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	538,900.00	538,900.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,388,800.00	5,388,800.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,344,900.00	17,328,729.00	-16,171.00	99.91
210301	Гэрэл, цахилгаан	2,643,400.00	2,627,229.00	-16,171.00	99.39
210302	Түлш, халаалт	14,701,500.00	14,701,500.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,666,000.00	20,663,100.00	-2,900.00	99.99
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,197,500.00	-2,500.00	99.79
210402	Тээвэр, шатахуун	14,500,000.00	14,499,600.00	-400.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	2,016,000.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950,000.00	950,000.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	22,678,100.00	22,678,100.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,478,100.00	14,478,100.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	5,750,000.00	5,750,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,450,000.00	2,450,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,844,500.00	4,844,500.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,250,000.00	1,250,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	3,594,500.00	3,594,500.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	1,496,100.00	1,474,000.00	-22,100.00	98.52
210702	Дотоод албан томилолт	1,496,100.00	1,474,000.00	-22,100.00	98.52
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,343,100.00	2,343,065.00	-35.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,493,100.00	1,493,065.00	-35.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	850,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,321,800.00	11,321,792.00	-8.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,321,800.00	11,321,792.00	-8.00	100.00

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	383,813,000.00	383,771,485.00	-41,515.00	99.99
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	345,117,400.00	345,103,316.00	-14,084.00	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	345,117,400.00	345,103,316.00	-14,084.00	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,939,400.00	20,923,229.00	-16,171.00	99.92
132001	Орон нутгийн төсвөөс	20,939,400.00	20,923,229.00	-16,171.00	99.92
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,756,200.00	17,744,940.00	-11,260.00	99.94
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	17,756,200.00	17,744,940.00	-11,260.00	99.94
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	0.00	0.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100.00
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	23.00	23.00	0.00	100.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	15.00	15.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	07.00	07.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	117,400.00	21,224,734.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	117,400.00	21,224,734.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	117,400.00	9,189,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,400.00	9,189,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,400.00	9,189,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	12035334.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	12,035,334.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	12,035,334.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	117400.00	21224734.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,400.00	21,224,734.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	117,400.00	21,060,334.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	164,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Эрүүл мэндийн төвийн дарга Г.Байгалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл,

анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 27-ээс 2021 оны 02 дугаар сарын 24-ны хооронд "Баянташаагийн эх аудит" ХХК-ний аудитор Ч.Чимгээ хариуцаж хэрэгжүүлэв.

Тус Эрүүл мэндийн төв нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг "Баянташаагийн эх аудит" ХХК-д 2021 оны 01 сарын 15 өдрийн 24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төв нь "эрхэм зорилгоо орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэн нотолгоонд тулгуурласан нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөжүүлснээр хүн амд ээлтэй тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж үйлчилгээг үзүүлэхэд оршино" гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 406613,5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8132,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 441243,1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8824,9 мянган төгрөгөөр тооцов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх гол үзүүлэлтүүдийг өмнөх онтой зэрэгцүүлэн судлахад өмнөх оноос бараа материал, үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	41,592.9	63,936.0	22,343.0
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	296.0	-	(296.0)
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	41,296.9	63,936.0	22,639.0
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	150,728.7	140,924.2	(9,804.5)
Үндсэн хөрөнгө	281,442.8	312,742.8	31,300.0
Хуримтлагдсан элэгдэл	(130,714.1)	(171,818.6)	(41,104.5)
Нийт хөрөнгө	192,321.7	204,860.2	12,538.6
Өр төлбөр	-	176.6	176.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	192,321.7	204,683.6	12,362.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	192,321.7	204,860.2	12,538.6

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 63936,0 мянган төгрөг болж 22639,0 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материал 5208,6 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан. Энэ нь цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эм боох материалын болон шатахууны нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас 12913,1 мянган төгрөгийн тендерийн эм, боох материал авснаас 6186,4 мянган төгрөгийг эмнэлэгт зарцуулж, эмнэлгийн эмийн эргэлтийн санд 6726,7 мянган төгрөгийн эм, боох материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 312742,8 мянган төгрөг болж 31300,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн Яамны хөрөнгө оруулалтаар автомашин олгосонтой холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 204683,6 мянган төгрөг болж 12362,0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 453605,1 мянган төгрөг болж, өмнөх оноос 58094,3 мянган төгрөгөөр буюу 12,8 хувиар өссөн байна.

Өмнөх оноос тусламж санхүүжилтийн орлого 8852,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 12470,3 мянган төгрөгөөр өсч, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 562,3 мянган, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 3055,8 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Нийт зардал 405026,5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 29959,6 мянган төгрөгөөр буюу 8,0 хувиар өссөн байна. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 32193,6 мянган, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4022,8 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3384,1 мянган, хангамж бараа материалын зардал 1882,3 мянган мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, норматив зардал 10225,6 мянган, урсгал засварын болон багаж техник хэрэгсэл худалдан авах зардал 8780,5 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний зардал 552,1 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд салбарын онцлогийг тусгасан сумын хүн амын болон багийн тоо, үйлчилгээний радиус, аймгийн төвөөс алслалтыг төлөвлөснөөс гадна цалингийн зардалд 254172,4 мянган, тогтмол зардал 17517,2 мянган, урсгал зардалд 8500,0 мянган, тэтгэвэрт гарах 3 хүний тэтгэмж 43142,4 мянган, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 2 ажилтны тэтгэмж 7942,2 мянган төгрөгийг төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тухайн онд төсвийг анх 387592,9 мянган төгрөгөөр баталсан байснаа 2 удаа тодотгол хийж, 383813,0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 383813,0 мянган төгрөгийн төсөв баталснаас 345103,3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 20923,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 17744,9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 345103,3 мянган, орон нутгийн төсвөөс 20923,2 мянган, эрүүл мэндийн даатгалын сангаас 17744,9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 383771,5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсвөөс 41,5 мянган төгрөг дутуу зарцуулсан нь томилолтын зардлыг 22,1 мянган, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 16,2 мянган, хангамж бараа материалын зардлыг 2,9 мянган, нэмэгдэл цалингийн зардлыг 0,3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулжээ.

Нийт төсөвт зардлын гүйцэтгэлийг хөтөлбөр арга хэмжээний зардлын гүйцэтгэлээр авч үзвэл үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээний зардал 25,3 мянган, байр ашиглалтын зардал 16,2 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардлын гүйцэтгэл /мянган.төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71808	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	383,813,0	383,771,5	(41,5)	100,0
1.1	81603	Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ	347,651,6	347,626,3	(25,3)	100,0
1.2	80109	Байр ашиглалтын үйлчилгээ	20,939,4	20,923,2	(16,2)	99,9
1.3	80302	Нэг хүнд ноогдох нормативт зардал	15,222,0	15,222,0	(00)	100,0

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны төсвийн хэлбэлзлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 21224,7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсний хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлсэн дэмжлэг 12035,3 мянган, Аймгийн ЭМГ-ын даргын 2020 оны А/133 тоот тушаалын дагуу тайлант онд үүссэн өр барагдуулахад зориулж 9025,0 мянган, Монголын сувиллагчдын нийгэмлэг НҮТББ-аас 164,4 мянган төгрөг хандивласнаар бүрдсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 3 ажиллагсад 12035,3 мянган төгрөгийн дэмжлэг олгож, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгт 5587,7 мянган, Нора ХХК-д нэг удаагийн хамгаалах хэрэгслийн өрөнд 3437,3 төгрөгийг шилжүүлж, 164,4 мянган төгрөгийг сорьц тээвэрлэлтийн зардалд өгсөн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 27 төрлийн 151 мэдээллээс 148 төрлийн мэдээллийг хугацаанд нь байршуулж, ажилд авах тухай байгууллагын даргын тушаал-1 хугацаа хоцорч байршсан, 2 мэдээний мэдээлэх хугацаа болоогүй байна.

Хүснэгт 3. Шилэн дансны мэдээлэл

Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	95	1	
	Нийт	27	151	148	1	2

Эх сурвалж: www.shilendans.gov.mn цахим хуудас

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2020 оны 05 дугаар сарын 21-өдрийн 36 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэл, тайлагнал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаа, байгууллагын онцлогийг тусгаагүй болон аймгийн ЭМГ-аас 12913,1 мянган төгрөгийн тендерийн бус эм, боох материал хуваарилж олгосон нь эргэлтийн эмийн санд ирсэн дүнгээс 1202,5 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа алдаа зөрчил илэрсэнд зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангаар залруулсан алдаа байхгүй.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгасан, бусад хэлбэрээр шийдсэн алдаа зөрчилтэй асуудал илэрсэнгүй.

Аудитын зөвлөмж

Тайлант оны санхүүгийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгох, эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл зөрүүтэй байгааг дахин тооцоо нийлж, цэгцлэх болон эмийн үлдэгдэл хэт их байгааг анхаарч Аймгийн ЭМГ-т санал тавьж шийдвэр талаар зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аймгийн хэмжээнд нэгдсэн журмаар эмийн тендерийн асуудлыг аймгийн ЭМГ нь зохион байгуулж, үнэгүй эм болон хамгаалах хэрэгсэл олгож байгаатай холбогдуулан эмийн ханган нийлүүлэлтийн асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

Суманд 6726,5 мянган төгрөгийн буюу их хэмжээний үлдэгдэл байгаа нь эмийн хугацаа дуусах, алдагдах, үр дүн муутай зориулалт бусаар зарцуулагдах эрсдэл үүсч байгаа тул аймгийн ЭМГ энэ тал дээр мэргэжлийн байгууллагын хувьд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэл, тайлагнал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдаа муутай, байгууллагын онцлогийг тусгаагүй жишиг шинжтэй байна.

1.2. Эрсдэл: Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг үйл ажиллагааны онцлогтой нийцэхгүй байх

1.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Аймгийн ЭМГ-аас олгосон тендерийн бус эм, боох материалын дүн /12,913,151төгрөг/ сумын эм эргэлтийн эмийн сангийн хүлээн авсан дүн /11,710,686

төгрөг/ гэвс 1202465 төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь эмийн ханган нийлүүлэлтийн асуудал аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтын хувьд жигдрээгүй, бүртгэлээр тавих хяналт сул байгаатай холбоотой .

1.2. Эрсдэл: Төсөвт хөрөнгийн үр ашиг буурах мөн эмийн хэрэглээний хугацаа дуусах, алдагдах, зориулалт бусаар зарцуулагдах

1.3 Өгсөн зөвлөмж: Тайлант хугацааны санхүүгийн тайлангаар эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 1202465 төгрөгөөр зөрүүтэй байгааг дахин тооцоо нийлж, баталгаажуулах мөн сумын эмийн эргэлтийн 5524253 төгрөгийн үлдэгдэлтэй байгаад анхаарал тавьж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтыг мөрдөж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн харуу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тухайн удирдлага нарт талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:
АУДИТОР

Ч.Чимгээ
Огноо: 2021.02.24

Анхан шатанд хянасан:
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.24

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.24

5. Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр:	Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит		Аудитын код:	
2021				БНА-2021/139/СТА-ТШЗ	
Шалгагдсан байгууллагын нэр:		Хүрээмарал сумын Эрүүл мэндийн төв		Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэл, тайлагнал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдаа муутай, байгууллагын онцлогийг тусгаагүй жишиг шинжтэй байна.	0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Г.Байгалмаа Б.Мэндбаяр
2	Аймгийн ЭМГ-аас олгосон тендерийн бус эм, боох материалын дүн /12,913,151төгрөг/ сумын эм эргэлтийн эмийн сангийн хүлээн авсан дүн /11,710,686 төгрөг/ гэс 1202465 төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь эмийн ханган нийлүүлэлтийн асуудал аймгийн хэмжээнд удирдлага, зохион байгуулалтын хувьд жигдрээгүй, бүртгэлээр тавих хяналт сул байгаатай холбоотой .	1202,5	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	Г.Байгалмаа Б.Мэндбаяр
ДҮН		1202,5			

---oOo---